

**А. Д. Симуков (1902-1942) – судлаачийн амьдрал руу хөтөлсөн  
эдийн засаг-улс төрийн нөхцөл байдал**

**Удо Б. Баркманн\***

Хүмүүний амьдралыг олон санамсаргүй тохиолдол бужигнуулан өөрчилж байдаг. Тэдгээр нь нэгдэн сайн сайхан үр дагаварт хүрвэл аз хэмээн үзэж, бүтэлгүйтвэл ихэвчлэн өөрт ноогдсон заяа тавилан хэмээн ойлгоно. А. Д. Симуковын амьдралд сайн муу бүхнээс аль аль нь тохиосон билээ. Энэхүү судлаачийн санасандаа хүрч чадсан амьдралыг нь эргэцүүлж нэг үзвээс тэр тун ч аз жаргалтай нэгэн. Харин сталинизмын аллагын шуурганаар 025332 дугаарын ялтан болон хөнөөгдсөн түүний амьдралын гунигт төгсгөлийн талаар эргэцүүлбээс тэр туйлын азгүй тавилантай нэгэн гэмээр.

Энэ хүний амьдралын<sup>1</sup> гараа тун ч дардан замаар эхэлсэн мэт. Хэдийгээр ядуу тариачны гэр бүлээс гаралтай авч түүний эцэг Дмитрий Андреевич Симуковт томоохон аз тохион их сургуулийн боловсрол эзэмшиж, улмаар Санхүүгийн яаманд алба хаших болов. Тэрбээр гэр бүлийн амьдралдаа санаа зовох зүйлгүй болсон мэт. Симуков хүү тухайн үеийн Санкт Петербург хотын гуманист гимназид суралцаж дүүргэв. Хүү франц, герман хэлийг эзэмшиж чадаад алсын улс орнуудад очихыг, мөн байгалийн ухааны мэргэжил эзэмших талаар мөрөөдөх боллоо. Тэртээ холын улс орнууд түүний хувьд огт таньж мэдэхгүй хаалттай ертөнц биш байв. Симуковын авга ах Александр Яковлевич Миллер нь Бухар, Тегеран, Ливерпуль, Астрабад, Тавризадад тус тус дипломат алба хашиж байсан нэгэн. 1913-1916 онуудад Миллер Оросын ивээлд орсон Гадаад Монголын Нийслэл Хүрээн дэх ерөнхий консулын албыг хашиж байлаа.

Симуковыг 15 настай байхад Орос орон даяар хувьсгал өрнөж, өсөж яваа идэр залуу хүүгийн бүхий л мөрөөдлийг хийсгэн авч одов. Тухайн үеийн Хаант засгийн яам тамгын газрын олонхи түшмэдийн хувь заяаг дагаад түүний эцэг ч мөн нийгэмд эзэлж байсан байр сууриа

\* DAAD, Born

<sup>1</sup> П.Цолмон, Шар Дамдинсүрэн хэмээх А. Д. Симуков, УБ 1990; Н. А. Симукова, А. Д. Симуков, Вклад в Монголоведение неизвестные труды, *Mongolica*, Vol.5(26)1994, Ulaanbaatar 1994, х.357-363

хүү Симуков тариачны эдлэнд гурван жилийг өнгөрөөсөн байна. Хожим нь өлсгөлөн зовлонд нэрвэгдсэн Москва хотноо их сургуулийн дэргэдэх автомашины хөдөлгүүрийн техникийн курст суралцах боллоо. Түүний амьдралын зам мөр нэгэнтээ дурайтал тодорчихсон хэрнээ тухайн цаг үеийн үймээний хөлд нэрвэгдсээр явж байлаа.

Харин 1923 онд түүний од шүүрэх цаг иржээ. Хаант засгийн генерал, алдарт аялагч, судлаач П. К. Козловын үйл хэргийг Зөвлөлт засагт хэрэгтэй хэмээн үнэлж байсан тул Оросын Газар зүйн нийгэмлэгийн даалгавраар Монгол, Төвд рүү хайгуул судалгааны аялалд томилсон байна. Козлов газрын зураг зуруулахаар Симуковыг хамт авч явахаар шийджээ. Симуковыг энэ талаар ямар ч төсөөлөлгүйг болохыг мэдсэн авч Козлов түүнийг багийнхаа бүрэлдхүүнд багтаан оруулсан нь огт санамсаргүй хэрэг биш байлаа. Симуковын авга А. Я. Миллер ерөнхий консулын алба хашиж байсан цагаасаа л Козловыг таньдаг байсан юм. Мөн тэр өөр нэгэн чухал хүнийг таньдаг байжээ. Энэ нь гадаад хэргийн албаны ардын комиссарын орлогч Лев Михайлович Карахан юм. Тэрбээр Хаант оросын үеийн Гадаад хэргийн яамны дипломат ажилтан байв. Карахан И. Я. Коростовецийн дэргэд бичиг хэргийн алба хашиж байсны хувьд Монгол улстай онцгой харилцаатай байсан хүн. И. Я. Коростовец нь Оросын эзэн хааны даалгавраар 1912 онд Гадаад Монгол улсын автономит эрхийн тухай гэрээг Богд Гэгээний засгийн газартай байгуулж явсан хүн. Түүхийн баттай эх сурвалжид өгүүлээгүй хэрнээ өөр бусад шалтгааны улмаас Симуковыг аяллын багтаа оруулсан байж болох талтай. Ямар ч атугай хайгуул судалгааны аяллын багийн бүрэлдэхүүнд Зөвлөлтийн нууц албаныхан ч мөн багтан орсон байдаг.

1923 оны 9-р сард тэд Монгол улсыг зорин хөдлөв. Тус аяллын багийнхантай хамтран ажиллах хамгийн чухал түнш нь Нийслэл хүрээний Судар бичгийн хүрээлэн байлаа. Авгынхаа захиаг мэдээжээр биедээ авч явсан Симуков энэ хүрээлэнд хүрэлцэн ирээд Миллерийн хуучин хоёр танилтай учирсан байна. Хүрээлэнгийн захирал О. Жамьян нь Богд Гэгээний Засгийн газрын үед санхүүгийн орлогч сайд байсан агаад түүний бичиг хэргийн дарга, буриад авхаалжтай Ж. Цэвээн нь 1913 оноос Орос улсаас санхүүжүүлэн эмхэтгэн гаргаж байсан “*Шинэ толь хэмээх бичиг*” болон “*Нийслэл хүрээний сонин бичиг*” нэртэй хоёр ч сонинд эрхлэгчээр нь ажиллаж байв. Тэд хоёул тухайн үед Оросын консултай ойр дотно хамтран ажилладаг байжээ. Нийслэл хүрээнд ирээд Симуков мөн алдарт судлаач Свен Хедин зэрэг бусад сонирхолтой хүмүүстэй танилцав. Хайгуулын багийнхан 1925 оныг хүртэл ялангуяа Улаанбаатар хотоос хойш 100 орчим км алслагдан орших Ноён уулан дахь Хүннү нарын булшинд малтлага хийсэн байна. Тэдний малтлагын ажил үнэхээр гайхамшигтай үр дүнд хүрчээ. Түүхийн олдворууд нь хожуу үеийн Монгол нутаг дээрх эртний түүхийн талаар маш өргөн ойлголт өгч чадсан юм. Нэн ялангуяа Грекээс Хятад хүртэлх өргөн уудам нутагт урд өмнө нь огт төсөөлж байгаагүй соёлын болон бараа таваарын өргөн их солилцоо наймаа өрнөж байсан нь илрэв. Малтлагын ажил өндөрлөсний дараа аяллын багийнхан газар зүйн болон ургамал судлалын чиглэлээр хуваагдан газар зүйн хоёр чиглэлд хөдөллөө. А. Д. Симуковын хувьд энэхүү судалгааны аялал түүний хожмын практик үйл ажиллагааны дадлага туршлага суухад нь томоохон сургууль болж өгсөн билээ.

1926 оны 1-р сарын сүүлчээр Монгол улсын ерөнхий сайдын орлогч, Санхүү эдийн засгийн сайд А. Амар Зөвлөлт засгийн газартай өрнүүлж буй олон талт хамтын ажиллагааны явцад нэлээд таагүй хандаж буйгаа илэрхийлэхээр Москваг зорив. Тэрбээр Монгол улсын

худалдаа, тээврийн салбар дахь Зөвлөлтийн эдийн засгийн ноёрхлыг шүүмжлээд, улс орны эдийн засгийн бүтээн босголтод бодитой тусламж үзүүлэхийг шаардав. Түүнийг Гадаад хэргийн Ардын комиссар Г. В. Чечерин хүлээн авч ярилцав. Тэрбээр эдгээр нь тун чухал шаардлагууд хэмээн ойлгож байсан авч Москвагаас энэ мөчийг хүртэл улс төр, цэрэг армийн асуудлыг илүүтэй онцгойлон авч үзэж байсан юм. ЗСБНХУ нь улс төрийн хувьд Монголыг өөрийн талд татахыг хүсэж байгаа цагт энэ улсыг эдийн засгийн хувьд ч мөн адил өөд нь татах шаардлагатай боллоо. Үүний тулд Монголыг бүхий л талаас нь сайтар судлах ёстой байв. Гэтэл тухайн үед Монголыг бүтнээр нь хамруулсан байтугай итгэж болохуйц газрын зураг гэхээр юм ч үнэндээ алга байжээ. Ардын комиссаруудын зөвлөл энэ асуудалд 1925 онд анхаарлаа онцлон хандуулснаар “Монгол, Тувагийн Бүгд Найрамдах Ард Улс, Буриад-Монголын Автономит Социалист Зөвлөлийн БНУ-ыг судлах хороо”<sup>2</sup>-г эмхлэн байгуулжээ. Тус хороо нь цаашдаа үзүүлэх бүхий л тусламжийн үйл ажиллагааны арын албыг гүйцэтгэж дийлэхээр үйлдвэрлэх хүчнийг хэрхэн бий болгох талаар судлах үүрэг даалгавартай ажээ. Ингээд Монголын Засгийн газрын зүгээс тавьж буй шүүмжлэлийн улмаас энэхүү хорооны ажлыг шуурхайлах шаардлагатай тулгарлаа.

“Их улс төр” ийнхүү А. Д. Симуквын амьдралд хөл дүрэв. Козлов 1925 оны 1-р сард хайгуулын ажлын дүнг нэгэн хорооны өмнө тайлагнахаар Ленинград хотыг зорив. Энэхүү хуралдаанд Гадаад хэргийн Ардын комиссарын төлөөлөгч ч мөн оролцох ёстой байлаа. Тэрбээр тус хорооныхонд өөрийн хайгуулын багийн зарим гишүүдийг “Монгол улсыг иргэншлийн замд хөтлөн оруулах хөтөч багш”-ийн үүрэгтэйгээр Улаанбаатарт үлдээхийг зөвлөсөн байна. Хорооныхон энэхүү саналыг хүлээн авсан ба харин “холбоо харилцаагаа гүнзгийрүүлэх, Монгол улсад үзүүлэх улс төрийн нөлөөгөө гүнзгийрүүлэх”<sup>3</sup> зорилгоор энэхүү шийдвэрт хүрсэн хэмээн тайлбарлав. Ингээд тус хорооноос хайгуулын багийн гишүүд болох А. Д. Симук, С. А. Кондратов нарыг Улаанбаатар хот дахь Судар бичгийн хүрээлэнд мэргэжилтнээр томиллоо. Энэхүү шийдвэр гарсны дараахан Симук Орос улсад богино хугацаагаар очиж өөрийн үеэл Мелания Алексеевна Миллертэй гэрлэн, улмаар 1927-1-1-ний өдөр Монгол руу эргэн ирж эхний ээлжинд музей байгуулах ажилд ханцуй шамлан оржээ.

Оросын тал Монгол улсыг олон талаас судлах цогц хөтөлбөрийг шамдан боловсруулж, түүнийгээ хэрэгжүүлж эхлэв. 1923 онд Монголын баруун хэсэгт эхлүүлсэн геологи хайгуулын ажлыг Монголын дорно зүгт өргөжүүлэх шийдвэрийг 1925 оны 1-р сарын эцэс гэхэд хэдийнээ гаргачихсан байлаа. Учир нь энэ үед Монголд америкийн геологи хайгуулынхан ажиллаж байсан бөгөөд нэгэн баримт мэдээнд дурдсанаар энэ явдал “(шинээр байгуулагдсан) БНМАУ, ЗСБНХУ-ын ашиг сонирхолд хэрхэвч нийцэхгүй” байлаа<sup>4</sup>. 1925 онд эхлүүлсэн геологийн хайгуул шинжилгээний ажил Улаанбаатар хотоос эхлэн Туул голын ай савыг бүхлээр нь хамран, мөн Хэрлэн, Онон мөрний савыг даган уруудаж, Улаанбаатар-Замын Үүдийн чиглэлийн дагуу болон Улаанбаатар хотын ойр орчмын уурхайнуудыг бүхэлд нь хамарч чадав. Мөн 1925 онд Зөвлөлтийн судалгаа шинжилгээний байгууллагууд хамтран Монголын хойд хэсэгт ургамал судлалын судалгааны ажлууд хийж гүйцэтгэх,

<sup>2</sup> Комиссия по исследованию Монгольской и Тувинской Народных Республик и Бурят-Монгольской АССР

<sup>3</sup> Т. И. Юсупова, Монгол-Тибетская экспедиция П.К.Козлова 1923-1926 гг. и начало советских научных инициатив в Монголии, *Dialogue among Civilisations: Interaction between Nomadic and Other Cultures of Central Asia*, Ulaanbaatar, 458-р хуудас

<sup>4</sup> Монгол-Зөвлөлтийн соёл, шинжлэх ухаан, техникийн харилцаа (1921-1940), 1-р боть, УБ 2000,43-р хуудас

Монгол улсын нутаг дэвсгэрээр тархсан цаг уурын станцууд байгуулах шийдвэр гаргажээ. Энэхүү сүүлчийн шийдвэр нь Монголын нутаг дэвсгэр дээр байлдааны онгоцны нислэгийн талбайнууд байгуулж эхэлсэн Зөвлөлтийн цэрэг армийн ашиг сонирхолд нийцэж байсан хэрэг. 1926 оны 12-р сард Улаанбаатар хотноо санаа бодол цуглуулах, сэдэх зорилгоор Орос-Монголын ажил хэргийн клубыг байгуулав. Энэ клубээс Монгол улсын эдийн засгийн хөгжлийн үндсэн стратегийн чиглэлийг боловсруулан гаргав. Эдийн засгийг бүсчлэн хөгжүүлэх асуудлууд, худалдаа, тээвэр, санхүүгийн цогцолбор системийг бий болгох, мал аж ахуйг хөгжүүлэх болон аж үйлдвэрийн барилга байгууламжуудыг барьж байгуулах зэрэг бүхий л асуудлуудыг хамруулан авч үзсэн байна.

Симуков 1927 онд хэдийнээ бие даан хайгуулын ажил хийж эхлэв. Тэрбээр Ноён Уулын археологийн малтлагыг үргэлжлүүлснээс гадна Говийн бүсийн хоёр ч нутагт хүн ам суурьшуулах болон газар тариалан хөгжүүлэх боломжийг судалсан ажээ. Эдгээр нутгуудаар аялахдаа газрын зураг бүтээхэд шаардлагатай өгөгдлүүдийг бичиж тэмдэглэж авсан байна. Удаахь жил нь А. Д. Симуков С. А. Кондратевийн хамт Улаанбаатараас баруун болон баруун хойд зүгт орших нутгуудаар хайгуулын аялал хийж цогц судалгаанууд хийж гүйцэтгэжээ. Тэд нэн ялангуяа газар зүйн мэдээ баримт цуглуулан, газар нутгийн биет бүтцийн шинжилгээ хийж, сүм хийдүүд, геологийн олдоч зэргийг судалсан байна. Симуков нийтдээ 30 мянган шоо дөрвөлжин км нутаг дэвсгэрийг газрын зурагт хамруулж чадсан юм. Ийнхүү цогцоор нь судлах явцад нэлээд олон удаа мухардах, мэдлэг боловсрол дутах зэрэг бэрхшээлтэй тулгарч байлаа. Ц. Жамсраногийн С. Ф. Олденбургт илгээсэн захидалд ч мөн энэ талаар дурдсан байдаг. Тэрбээр ингэж бичжээ: “Симуков хэдийгээр шинэхэн судлаач боловч ямар ч атугай шинжлэх ухаанд боловсрох зайлшгүй хэрэгтэй байна.”<sup>5</sup>

1929 онд Монгол улсын Засгийн газрын байгууллагууд ЗСБНХУ-ын ШУА-тай хамтран Монгол улсын нутаг дэвсгэр дээр эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийж гүйцэтгэх таван жилийн ажлын төлөвлөгөөг баталж гаргажээ. Энэхүү тогтоол шийдвэрийн хүрээнд мал аж ахуйг “эдийн засгийн суурийн суурь дэвсгэр” хэмээн тодорхойлсон байдаг. Иймээс “малын үүлдэр угсааг сайжруулан, үр өгөөжийг нэмэгдүүлэх”, түүнчлэн “мал аж ахуй, газар тариалангийн цаашдын хөгжлийг залуурдан зохион байгуулах бүтцийг бий болгох боломж”-ийг судалж тогтоох нь хамтарсан цогц хайгуулын нэн тэргүүний үүрэг болоод байв. Нийгмийн тогтолцоог өөрчлөн зохион байгуулах санааг агуулсан “улс орны эдийн засгийн хөгжлийг хувьсгалт бодлогод нийцүүлэн зохицуулах”<sup>6</sup> тухай тогтоолын заалт нь тухайн үеийн ЗХУ-ын улс төрийн ягшмал үзэлд хэдийгээр нийцэж байсан авч тухайн үеийн Монголын нийгмийн бүтцийн хувьд энэ нь тун ч дэвшилттэй санаа байсан билээ. 1929 оны 10 дугаар сарын 5-ны өдрийн ЗСБНХУ-ын ШУА, Судар бичгийн хүрээлэнгийн хооронд байгуулсан хамтын ажиллагааны гэрээний дагуу Монгол улсад геологи, геохими, палеонтологи, гидрологи, хөрс судлал, ургамал судлал, амьтан судлал, эрт галавын угсаатны зүй, археологи, хүн судлал, угсаатны зүй, хэл шинжлэлийн салбаруудад шинжилгээ судалгааны ажил хөгжүүлэхээр заажээ. 1929 оны 12-р сард Монгол улсын улс ардын аж ахуйг хөгжүүлэх төлөвлөгөөг боловсруулахаар ЗСБНХУ-аас ажлын комиссын гишүүд Улаанбаатар хотноо хүрэлцэн ирэв. Үүнээс цөөн долоо хоногийн хойно ЗСБНХУ-ын

<sup>5</sup> 104-р хуудас

<sup>6</sup> 168-р хуудас

Төлөвлөгөөний комиссын дэргэдэх Эдийн засаг судлалын хүрээлэнд Монгол улсын эдийн засгийг судлах ажлыг үүрэгдэв<sup>7</sup>. Төлөвлөгөөний комиссын үйл ажиллагааны талаар нарийн мэдээлэл байдаггүй авч өмнө нь хийж байсан судалгааны материалууд дээр үндэслэн нэн чухал шийдвэрүүд гаргаж байсан болов уу. Ингээд УБХ-аас 1930 оны 11-р сарын 6-ны өдөр “БНМАУ-ын засаг захиргааны хуваарилалтыг өөрчлөн шинэчлэх тухай хууль”-ийг батлан гаргасан ба энэ хуулийн үндсэн дээр 1931-2-6-ны өдөр Засгийн газрын тогтоол гарч, 2-р сарын 7-ны өдөр УБХ-аас тухайн үеийн таван аймгийг тарааж нийтдээ 13 аймаг болгон өөрчилсөн тогтоол гаргаж байлаа<sup>8</sup>. УБХ-ын тогтоол нь засаг захиргааны шинэчлэлийн үндсэн дээр Монгол улсын нутаг дэвсгэрийг “төлөвлөгөөний дагуу, адил тэнцүү” хөгжүүлэх санаа агуулсан нь илт. Ийнхүү цогцоор нь хөгжүүлэх нь Зөвлөлтийн хувьд нэн ялангуяа дэд бүтцийг төлөвлөх болон хүн амд албан татвар оноох ажлыг хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай алхам байв.

ЗСБНХУ-ын Засгийн газар өөрийн төлөвлөгөөг хэргэжүүлэхээр шуурхайлах боллоо. Тэрбээр 1930 онд Монголын талтай хамтран Улаанбаатар хотноо аж үйлдвэрийн комбинатыг барьж байгуулахаар тохиролцов. Энэхүү аж үйлдвэрийн цогцолборын хүрээнд нэхмэл эдлэлийн үйлдвэр, цэмбэний үйлдвэр, эсгийний үйлдвэр, ноос угаах цех болон арьс шир боловсруулах үйлдвэр байгуулагдахаар болсон байна. 1931 оны 5-р сарын 25-ны өдөр ЗСБНХУ-ын Ардын комиссаруудын зөвлөлөөс (Сайд нарын зөвлөл) Хүнд аж үйлдвэрийн ардын комиссаруудын хорооны дэргэд байгуулагдсан геологийн судалгааны орон тооны судалгааны багийг хоёр жилийн хугацаатайгаар Монгол улсад илгээн ажиллуулах тогтоол гарав. Үүнээс улбаалан 1932 оны 8-р сарын 1-ний өдөр Ардын комиссаруудын хороо болон Монгол улсын Худалдаа, аж үйлдвэрийн яамны хооронд “БНМАУ-д одоо байгаа болон ирээдүйд байгуулах уул уурхайн үйлдвэрүүдийг шаардлагатай түүхий эдээр хангах, нөөцийг эрж хайн, хэмжээг олж тогтоох, ашигт малтмалыг ухааж ашиглах”<sup>9</sup> зорилго бүхий хамтын ажиллагааны гэрээ байгуулжээ. 1931 – 1934 онуудад хийсэн эрэл хайгуулын ажил гол нь алт, өөхөн чулуу, нүүрс, бал чулуу, занар, барилгын материалууд, ховор металлын (молибден, вольфрам, тугалга) нөөцийг илрүүлэх, мөн Улаанбаатар хотын ойр орчмын болон Хэнтий, Өмнөговь, Дорноговь, Дорнод аймгууд дахь гүний усны нөөцийг тогтоох зорилготой байлаа. Геологичид нийтдээ 70,101 шоо дөрвөлжин км нутаг дэвсгэрийг хамруулсан 1:500.000-аас 1:10.000 хүртэл масштаб бүхий геологийн, усны болон байгалийн нөөцийн газрын зураг бүтээсэн байна.

Хамтарсан цогцолбор экспедиц 1932 оны эхээр мал аж ахуй, геологи-хайгуул зэрэг стратегийн гол чиглэлүүдээр чухал үр дүнд хүрэв. Тэд мал аж ахуй болон түүний газар зүйн байршлыг бүх талаар нь судалж, сүргийн бүтцийг боловсронгуй болгох, малын үүлдэр угсааг сайжруулах, үйлдвэрлэлийнх нь үр ашгийг нэмэгдүүлэх арга замуудыг тодорхойлон, Монгол орны газар нутгийг бүхэлд нь хамарсан газрын тогтоц-ургамалжилтын зураг, мөн тэжээлийн гол гол ургамлын тархалтыг харуулсан газрын зургийг тус тус бүтээжээ.

<sup>7</sup> Монгол-Зөвлөлтийн соёл, шинжлэх ухаан, техникийн харилцаа (1921-1940), 1-р боть, УБ 2000, 148-р хуудас

<sup>8</sup> нэмж харах: Udo B. Barkmann Landnutzung und historische Rahmenbedingungen in der Äusseren Mongolei/ Mongolischen Volksrepublik (1691-1940), = Senri Ethnological Reports 17, Osaka 2000

<sup>9</sup> Монгол-Зөвлөлтийн соёл, шинжлэх ухаан, техникийн харилцаа (1921-1940), 1-р боть, УБ 2000, 258-р хуудас

Хайгуулчид ашигт малтмалын орд газруудыг олж тогтоосноор тэдгээрийг газрын зурагт оруулах чухал нөхцлийг бүрдүүлэв. Тэрчлэн усны хайгуул, мөн хүн амын нийгмийн бүтцийн талаар явуулсан судалгаанууд ч ихээхэн урагшилсан байна.

Малаж ахуйн судалгааны баг 1931 оноос хойш говийн бүсийн өмнөд тал (Дорноговь, Өмнөговь аймгууд) болон хангайн бүсийн төв хэсгүүдээр (Архангай, Өвөрхангай аймгууд) явуулсан шинжилгээний аяллаараа малын үүлдэр угсааг судлах, эдгээр үүлдрийн үр ашгийг дээшлүүлэх зэргээс гадна бэлчээрийн аж ахуй, хадлан тэжээл бэлтгэн нөөцлөх асуудалд голлон анхаарчээ. А. Д. Симуков энэхүү экспедицийн үйл ажиллагаатай илүү их холбоотой байв. Тэрээр газар зүйн нээлтүүдээ үргэлжлүүлэхийн зэрэгцээ давын өмнө эдийн засгийн газар зүйн асуудлууд өөрийнх нь үйл ажиллагаанд зонхилох болж буйг олж хараад: “Одоо бол миний судалгааны ажилд хүн, түүний эрхэлж буй аж ахуй, аж төрөл, эдийн засаг ихээхэн байр суурь эзлэх болов. Миний бие ... нутаг орны газар зүйн тогтцыг авч үзэхдээ, энэхүү тогтцын элементүүдийг улс орны эдийн засагт ашиглаж болох хамгийн оновчтой арга замуудыг хайж буй хүний үйл ажиллагааны талбар гэж үздэг”<sup>10</sup> хэмээн бичиж байлаа. А. Д. Симуков мэтийн судлаачид бол Монгол орныг бүхэлд нь нээн илрүүлээд зогсоогүй, уг ажлыг хийж гүйцэтгэснээрээ тус орны эдийн засаг-нийгмийг өөрчлөн байгуулахад зайлшгүй шаардлагатай мэдлэг оюуныг бий болгож чадсан нь чанарын хувьд цоо шинэ зүйл болсон юм.

Судалгааны үр дүн юуны өмнө нийслэл Улаанбаатар хотыг Монгол улсын аж үйлдвэрийн анхны төв болгон хөгжүүлэхэд зориулагдав. Улаанбаатарыг хөгжүүлэе гэвэл түүний алс хэтийн ирээдүйг бодож хүмүүсийг олноор суурьшуулан, барилга байшин барьж, зам тээврийн тогтолцоог нийслэлд төвлөрүүлэх зэрэг ажлууд хийгдэх учиртай байлаа. Энэ нь хүнсний зүйлс, барилгын материал, ундны болон ахуйн хэрэглээний ус, түүнчилэн нүүрс, эрчим хүчийг ойр орчны газруудаас улам их хэмжээгээр татан авчирна гэсэн үг бөгөөд чухам энд л А. Д. Симуков зэрэг судлаачдын хийсэн ажлыг практикт хэрэглэх шаардлага онцгой их тавигдах болжээ. Шинэ тутам олж авсан мэдлэгийг логик дэс дараагаар нь амьдралд асар хурдан нэвтрүүлж асан явдал хүмүүсийн бахархлыг төрүүлж байсан нь эргэлзээгүй. 1934 оны хоёрдугаар сарын 26-нд Улаанбаатар хотноо хоёр турбин-хөдөлгүүр бүхий цахилгаан станцыг ашиглалтад оруулснаас хойш нэг жилийн дараа 1935 оны гуравдугаар сарын 26-нд Аж Үйлдвэрийн Комбинатыг хүлээлгэн өгөв. Зөвлөлтийн тал 1931/1932 онуудад аж үйлдвэрийн энэхүү хоёр цогцолборт ажиллуулахаар таван зуун ажилчныг сургажээ. Зөвхөн Монголоос гаралтай түүхий эдийг боловсруулах тус комбинатыг ашиглалтад оруулсан явдал хөгжил гэдгийг үзээгүй шахам Монгол орны хувьд бараг хувьсгалын шинжтэй үйл явдал болсон юм. 1935 онд нийт монгол ажилчдын 65 хувь нь дээрх комбинатад ажиллаж, улс орны аж үйлдвэрийн цэвэр бүтээгдэхүүний 75 хувийг үйлдвэрлэн гаргаж байсан аж. Үйлдвэрлэлийн хурдан өсөлт удалгүй эрчим хүчний үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэхийг шаардах болов. Гиймийн учир Зөвлөлтийн мэргэжилтнүүд 1937-1938 онуудад Налайхын нүүрсний уурхай, Улаанбаатарын Цахилгаан Станцын хооронд 43 км урт төмөр зам төмөр зам тавилаа. Налайх 1937 онд өөртөө цахилгаан станцтай болсон ба 1939 он гэхэд Улаанбаатар дахь цахилгаан станцын хүчин чадлыг 5.500 кв-ад хүргэх шаардлагатай болжээ. Мөн онд Улаанбаатар, Налайхын хооронд өндөр хүчдэлийн шугам тавьсан явдал

<sup>10</sup> Н. А. Симукова, А. Д. Симуков, Вклад в Монголоведение неизвестные труды, *Mongolica*, Vol. 5(26) 1994, Улаанбаатар 1994, 358-р тал.

Налайхын уурхайн эрчим хүчний хангамжийг тогтворжуулж, нүүрс олборлох үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэхэд шийдвэрлэх нөлөө үзүүлэв.<sup>11</sup>

1930 оны 12-р сарын 20-ноос эхлэн “Шинжлэх Ухааны Хүрээлэн” хэмээн нэрлэгдэх болсон Судар Бичгийн Хүрээлэнгийн харьяа, А. Д. Симуковын удирдсан Газар зүйн хэлтэс Монгол орныг цогцолбороор хөгжүүлэх үйл явцад туйлын чухал хувь нэмэр оруулсан билээ. А. Д. Симуковын хийсэн нэгэн судалгаанаас<sup>12</sup> үзвэл түүний эрдэм шинжилгээний ажлууд дараах үе шаттайгаар хийгджээ. Үүнд:

1. 1923-1924 онуудад Монгол-Хятадын хилийн дагуух өмнөд нутгуудаар газар зүйн судалгаа хийсэн. Эдгээр судалгаа нь Хятадын эдийн засгийн хараат байдлаас ангижрах эрмэлзлийг баримталж байснаараа стратегийн шинжтэй байв.
2. 1926-1928 онуудад Хэнтийн уулархаг нутгуудыг төлөвлөгөөтэйгээр судалсан.
3. 1928-1935 онуудад говь болон хангайн бүс нутгуудыг төлөвлөгөөтэйгээр судалсан. Говьд хийсэн судалгаанууд нь тус бүс нутгийн гуравны нэгийг хамарч байв.

Дээрх гурван үе шаттайгаар явагдсан судалгааны ажлуудын эцэст тэдгээрийн үр дүнг тодорхой системд оруулж, нэгтгэн дүгнэх зайлшгүй шаардлага урган гарчээ. Энэ ажлыг дараах таван шатлалтайгаар хийж гүйцэтгэсэн байна:

1. Хувьсгалын өмнөх үеийн судалгааны материалуудыг шүүмжлэлтэйгээр авч үзэх (тухайлбал, Баруун Монгол буюу Увс, Ховд аймгийн нутгууд Грум-Гржимайлов зэрэг эрдэмтдийн зүгээс нилээд судлагдсан байв). Эдгээр материалыг нягтлан үзэхдээ Монголын хуучин газрын зургуудыг ч оролцуулжээ.
2. Шинжлэх Ухааны Хүрээлэнгийн Газар зүйн хэлтсийн хээрийн судалгааны ажлын үр дүнгүүдийг системчлэх
3. Зөвлөлтийн болон Монголын тусгай экспедицүүдийн гаргасан газар зүйн мэдээ баримтуудад сонголт хийх
4. Шинжилгээний ажлын явцад орон нутгийн оршин суугчдаас авсан мэдээллүүдэд дүгнэлт хийх (нутаг бэлчээрийн хуваарилалт, малын ус, тэжээлийн хангамж, малын үүлдэр угсаануудын онцлог, малчдын ахуй амьдралын онцлог г.м.)
5. Энэ бүх материалыг олж нэгтгэн, шүүмжлэлтэйгээр нягтлан шалгах

Судалгааны материалуудыг нэгтгэн дүгнэснээр танин мэдэхүйн дараах үр дүнд хүрэв. Үүнд:

1. Байгаа баримт материалуудаа нэгтгэн дүгнэсний үндсэн дээр гадаргуугийн тогтцын үндсэн физик шинжүүд, түүнийг бүрдүүлэгч элементүүдийн хоорондох харилцан шүтэлцээний талаар дүгнэлт өгөх боломжтой болсон.
2. Уур амьсгалын болон ургамлын бүсүүд, тэдгээрийн хэвтээ, босоо бүдүүвч хийгээд хил хязгаарыг тодорхойлсон. Мөн ургамлын аймгийн бүтцийг анх удаа тогтоож,

<sup>11</sup> Монголын хөнгөн аж үйлдвэр, тэргүүн дэвтэр, Улаанбаатар 2004 -ийг үзжү.

<sup>12</sup> № 472, Мая 1936, Улан-Батор, А. Д. Симуков, Итоги работы географического отделения научно-исследовательского комитета МНР за 15 лет.

- ургамлын төрөл зүйлтэй хамаарал бүхий хөрсний хэв шинжүүдийг тодорхойлсон.
3. Нийт газар нутгийн хэмжээнд оршин амьдарч буй мал, сүүн тэжээлт том амьтдын тархалтыг үндэслэн амьтны аймгийн бүсчлэлийг тодорхойлсон.
  4. Тус орны онцлогийг илэрхийлсэн томоохон бүс нутгуудыг газрын тогтоц, цаг уур, ургамал, амьтан, хөрсний хэв шинж гэсэн үзүүлэлтүүдээр ангилан тогтоосон.
  5. Монгол орны нутаг дэвсгэр дээрх томоохон бүс нутгуудын гадаргуугийн байдлын өөрчлөлтийг үндэслэн газар зүйн мужууд гэдэгт хуваан үзэх боломж бүрдсэн нь юуны өмнө мал аж ахуйг онцлогийг судлахад ихээхэн ач холбогдолтой зүйл болов.

Ийнхүү танин мэдэхүйн багагүй хэмжээний мэдлэг олж авсан нь сүүлдээ “Бүгд Найрамдах Монгол Ард Улсын газар зүйн тойм зураг”, “Бүгд Найрамдах Монгол Ард Улсын говийн бүс нутаг”, “Төв хангай” зэрэг системчилсэн дан сэдэвт бүтээлүүд, тэрчилэн Бүгд Найрамдах Монгол Ард Улсын газар зүйн болон эдийн засгийн атласыг бүтээх боломжийг буй болгосон билээ.

Газар зүйн талаар олж авсан мэдлэг, түүнчилэн тус орны эдийн засгийн амьдрал, нэн ялангуяа мал аж ахуйн талаар цуглуулсан мэдээ баримтуудыг нэгтгэн дүгнэсний үндсэн дээр яваандаа аймаг тус бүрийн доторх бичил эдийн засгийн бүсүүдийг ч мөн бэлчээр, түүний хуваарилалт, менежментийн чиглэлээр хийсэн судалгаануудтай хавсран тогтоосон аж.

Цогцолбороор нь авч үзвэл, газар зүйн талын эдгээр мэдлэг туршлага юуны өмнө бэлчээрийн ашиглалт, малын тоо толгой хоорондын харилцан хамаарлыг хүний оролцоонд тулгуурлан зохистойгоор зохицуулахад чиглэх ёстой хөдөө аж ахуйн нэгдлүүдийн тогтолцоог үүсгэн бий болгох явдлыг урт хугацаагаар төлөвлөх шинжлэх ухааны урьдач нөхцөл болсон гэхэд болно. Гэвч хожим энэ механизм үүргээ биелүүлж чадаагүй ба тэр нь тус орны эдийн засгийг зөвлөлтийнхний гараар хөмрүүлэхэд хүргэсэн улс төрийн тогтолцоотой нь юуны өмнө холбоотой юм.

Зах зээлийн эдийн засгийн харилцаа өнөөгийн Монголын мал аж ахуйд хэрхэн нөлөөлж байгааг авч үзэхүй ямар ч зохицуулалтгүй зах зээлийн үйлчлэл Монгол орныг экологийн талаар ихээхэн хохирол амсахад хүргэж, энэ нь хүн-байгаль орчны харилцан шүтэлцээнд удаан хугацааны турш сөрөг нөлөө үзүүлэх нь тодорхой болоод байна.

Бий болоод байгаа асуудлуудыг шийдвэрлэхийн тулд бүхэл бүтэн, цогц судалгаа эхлүүлэх шаардлагатай, тэр нь яв явсаар Монголын нүүдлийн мал аж ахуйг шинээр зохион байгуулах мастер төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэхэд хөтлөн аваачих учиртай юм. Энэ утгаар нь авч үзвэл А. Д. Симуковоос суралцах зүйл өнөөдөр ч гэсэн цөөнгүй байна. Чухамхүү эдгээр элементүүд, өөрөөр хэлбэл бүхэл бүтэн, цогц судалгааны ажил эдүгээ, тухайлбал Монгол Улсын нутаг дэвсгэрийг засаг захиргааны нэгжүүдэд хуваах шинэ журмын тухай ид яригдаж байгаа энэ үед үгүйлэгдсээр байгаа билээ. Хэрвээ Монгол Улс бичил эдийн засгийн бүсүүдийн талаарх шинэхэн судалгаануудын тухай энэхүү яриагаа Монголын мал аж ахуйн байгаль-экологид халгүй, уламжлалт элементүүдийг орчин үеийн шинжлэх ухааны мэдлэг туршлагад дулдуйдан зохион байгуулалтын орчин цагийн хэлбэрүүдтэй хир зэрэг уялдуулах тухай яриа хэлэлцүүлэгтэй холбож чаддаг сан бол их зүйл хожих сон. Ингэх аваас Монгол Улс экологийн чиг баримжаа бүхий орчин үеийн хөдөө аж ахуйн орон болох тов тодорхой хэтийн төлөвлөгөөтэй улс болох билээ.